



“Хариуцлагатай уул уурхай ба хорт бодисын зохистой хэрэглээ” сэдэвт бүсийн семинар зохион байгууллаа

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Байгаль орчны яамтай хамтран “Хариуцлагатай уул уурхай ба хорт бодисын зохистой хэрэглээ” сэдэвт бүсийн семинарыг 2006 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан хотод зохион байгууллаа./Семинарын хөтөлбөрийг хавсаргав/.



Семинарт Улсын Их Хурлын гишүүн Ч. Раднаа, Г.Адъяа, Байгаль орчны дэд сайд Б.Энхмандах, Дархан-Уул, Орхон, Төв, Булган аймгийн Засаг дарга болон Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга нар эдгээр аймгийн 20 орчим сумдын дарга мөн аймгийн Байгаль орчны болон Мэргэжлийн хяналтын албадын дарга, Улсын мэргэжлийн хяналт, Улсын онцгой байдлын ерөнхий газар, эдгээр байгууллагуудын холбогдох мэргэжилтэн, байцаагчид, зарим төрийн бус байгууллагын төлөөлөгчид нийт 90 гаруй хүн оролцлоо.

Эдгээр аймгуудад уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явуулснаас үүдэж байгаль орчны бохирдол, доройтол улам ихсэж байгаа юм. Ялангуяа сүүлийн

жилүүдэд онц хортой химийн бодисын хэрэглээ өгч, улмаар зарим газар хууль бусаар мөнгөн ус хэрэглэж алт олборлох үйл ажиллагаа эрчимжиж байгаагаас орчны хүн ам хордон, ус, хөрс их хэмжээгээр бохирдож байгаа юм. Гэтэл эдгээр газрууд нь манай улсын гол үржил шимтэй газрууд бөгөөд газар тариалангийн гол бүс нутаг билээ.

Иймд бид аливаа уул уурхайн үйл ажиллагааг нийгэм, эдийн засаг, байгаль орчиндоо хариуцлагатайгаар явуулах гэсэн олон улсын хэмжээнд баримталж буй чиг хандлага зарчмыг хэрэгжүүлэх үүднээс “Хариуцлагатай уул уурхай”-г хөгжүүлэх нийгмийн шаардлага, түүнийг хэрэгжүүлэх арга зам, үндсэн зарчим болон химийн хорт ба аюултай бодисын уул уурхайн салбарт өргөн хэрэглэж байгаагаас үүсэж буй бэрхшээл, түүнээс сэргийлэх арга хэмжээ, Ашигт малтмалын шинэчилсэн хуулийн хэрэгжилтэд орон нутгийн байгууллагаас юуг анхаарах, яаж хяналт тавих, түүнчлэн уул уурхайн компаниудтай хамтран ажиллах, орон нутгийн оролцоотой менежментийг хэрхэн явуулах талаар хэлэлцэж, нэгдсэн ойлголттой болох, мэдээлэл солилцох зорилгоор энэхүү семинарыг зохион байгуулж байгаа юм.



Энэ семинар нь манай улсад химийн хорт ба аюултай бодисын тухай хууль болон ашигт малтмалын хуулийг шинэчилэн батлуулсаны дараа болж байгаагаараа онцлого бөгөөд “Хариуцлагатай уул уурхай”-г хөгжүүлэх гэсэн шинэлэг зарчим бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг танилцуулах чухал арга хэмжээ боллоо.

**“Хариуцлагатай уул уурхай ба хорт бодисын зохистой хэрэглээ”
бүсийн семинарын
ХӨТӨЛБӨР**

11 дүгээр сарын 17-ны Баасан гараг

17:00 Төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулна.

19:00 Оройн хоол

11 дүгээр сарын 18-ны Бямба гараг

09:30 Семинарт оролцогчдыг бүртгэж танилцуулах

10:00 **Семинарыг нээж УИХ-ын гишүүн Ч.Раднаа үг хэлэх.**

10:20-10:40 **Ашигт малтмалын тухай шинэ хуулийн байгаль хамгаалах бодлого, түүнийг орон нутагт хэрэгжүүлэх арга замын тухай**
Ч.Раднаа - УИХ-ын гишүүн, хуулийн байгаль хамгаалах бодлогын асуудлыг хариуцан ажилласан ажлын хэсгийн ахлагч

10:40-11:00 **Уул уурхайн салбарын байгаль орчны менежментийн асуудал**
Б.Энхмандах - Байгаль орчны дэд сайд

11:00-11:20 **Дэлхийн байгаль хамгаалах сангаас уул уурхайн чиглэлээр баримталж буй бодлого**
Б.Чимэд-Очир - ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газрын захирал

11:20-11:35 Цайны завсарлага

11:35-11:50 Асуулт, хариулт

11:50-12:20 **“Хариуцлагатай уул уурхай”-г хөгжүүлэх ерөнхий зарчим, хэрэгжүүлэх арга зам**
Л.Долгормаа/Ph.D / - ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газрын ажилтан

12:20-12:40 **Уул уурхайн үйл ажиллагаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудал**
Г.Батсайхан- БОЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын орлогч дарга

12:40-13:00 Асуулт, хариулт

13:00-14:00 Үдийн хоол

14:00-14:30 **Химийн хорт ба аюултай бодисын тухай шинэ хуулийн үзэл баримтлал , түүнийг хэрэгжүүлэх тухай**
Ч.Раднаа-УИХ-ын гишүүн, хуулийг санаачлагч

14:30-15:00 **Уул уурхайн салбарт хэрэглэж буй химийн хорт ба аюултай бодисын сөрөг нөлөөлөл анхаарах асуудал**
Л.Долгормаа/Ph.D / - ДБХС-гийн Монгол дахь Хөтөлбөрийн газрын ажилтан

15:00-15:20 **Уул уурхайн салбарт хэрэглэж буй химийн бодис, хэрэглээний өнөөгийн байдал зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудал**
Б.Саран - Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин, уул уурхай хяналтын улсын албаны дарга
Б.Отгон - УМХГ-ын химийн бодисын хяналтын улсын байцаагч

15:20-16:00 **Химийн хорт бодисын осол, эрсдлийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал**
Ч.Батчулуун- Онцгой байдлын ерөнхий газрын онцгой үеийн шуурхай удирдлагын орлогч дарга

16:00-16:20 **Уул уурхайн салбар дахь хүний эрхийн асуудал**
Д.Эрдэнэчимэг- Хүний эрхийн хөгжил төвийн хуульч

16:20-16:30 Цайны завсарлага

16:30-18:00 Асуулт хариулт, Ярилцлага

18:00-18:15 **Семинарыг хааж үг хэлэх**
Ч.Раднаа- УИХ-ын гишүүн

18:30 Оройн зоог

11 дүгээр сарын 19-ний Ням гараг

9:00 Өглөөний цай

10:00 Төлөөлөгчид буцах